

Article

Trends in the Development of Family Courts

Enkhbayar Battur^{1*}, Gantumur Galbat²

¹Department of Public Law, School of Law, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

²Department of Public Law, School of Law, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: enkhbayar@otgontenger.edu.mn

 <https://orcid.org/0009-0005-0399-4383>

Received: 20 March 2026. Accepted: 20 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

In Mongolia, the adjudication of family-related cases has traditionally been governed by civil procedural law, and this historical approach continues to the present day. However, in many countries worldwide, there is a growing trend toward resolving family disputes and juvenile offences through specialized courts. In this context, Mongolia is currently discussing a draft Law on Family Case Procedure and is simultaneously preparing for the establishment of specialized family courts.

Although the Law on the Establishment of Courts provides that specialized family courts shall commence adjudication of cases starting from January 1, 2026, the Law on Family Case Procedure—which is intended to regulate the legal basis and procedures of these courts—has not yet been adopted. Nevertheless, the forthcoming Law on Family Case Procedure is expected to incorporate both Mongolia's legal traditions and socio-cultural characteristics, while also integrating best practices from foreign jurisdictions, and to establish a legal framework that effectively safeguards the interests of families and children.

This paper aims to examine the development of family court systems and selected legal regulations on family case procedures in various countries, and to conduct a comparative analysis with Mongolia's current legal framework, socio-legal conditions, and national characteristics. To achieve this objective, the study employs historical and comparative research methods.

Keywords

Family cases, family case adjudication, law on family case procedure, family court



© 2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Гэр бүлийн шүүхийн хөгжлийн чиг хандлага

Баттөрийн Энхбаяр¹, Галбатын Гантөмөр²

^{1,2}Отгонтэнгэр их сургууль, Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхим, Улаанбаатар хот, Монгол улс

Хураангуй

Монгол Улсад гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг иргэний процессын хуулиар зохицуулж ирсэн түүхэн уламжлал өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Гэвч дэлхийн олон улс оронд гэр бүлийн хэрэг, хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг дагнасан шүүхээр шийдвэрлэх чиг хандлага баримталж байгаа өнөө үед Монгол Улсад Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг явагдаж байгаагаас гадна гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулагдах бэлтгэл ажлыг хангаж байгаа болно. Иймд энэхүү илтгэлээр дэлхийн улс орнуудад үүсэж хөгжсөн гэр бүлийн шүүх, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны өнөөгийн онцлог, нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахыг зорьсон болно. Иймд энэхүү илтгэлийг бичихэд түүхчлэх болон харьцуулалтын аргыг хэрэглэсэн.

Түлхүүр үгс

Гэр бүлийн хэрэг, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, гэр бүлийн шүүх

Удиртгал

Монгол Улсад эрүү, иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн харилцааг нэг хуулиар зохицуулж байсан түүхэн үе ч бий. Харин 1967 оны 6 сарын 29-нд БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль баталсанаар гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагаа энэхүү хуулиар зохицуулагдсан бөгөөд үүнээс хойш түүнд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан ба шинэчлэн найруулсан. Одоогийн байдлаар 2002 онд баталсан Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн зохицуулалтыг хэрэглэн гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ ердийн иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэж байна. Удахгүй гэр бүлийн дагнасан шүүх байгуулагдаж үйл ажиллагандаа баримтлах Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд заасан зарим эрх зүйн зохицуулалтад санал дүгнэлт гаргасан болно.

Үндсэн хэсэг

Гэр бүл, хүүхдийн шүүхийн зорилго нь зөвхөн хууль хэрэглэж бус, харин олон шинжлэх ухааны мэдлэг, ололт амжилтыг ашиглан тухайн салбарт мэрэгшсэн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаанд тулгуурлаж, хүүхдийн эрх, ашиг сонирхолыг дээдэлсэн, тухайн хэрэг, маргаанд хамаарал бүхий гэр бүлийн гишүүд, бусад хүмүүст тохирох хамгийн зөв, цогц шийдлийг олоход чиглэдэг.

Харин энэхүү илтгэлийн хүрээнд зөвхөн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн тогтолцоо үүсэж, хөгжсөн түүхэн үе шат болон түүнийг өөрийн оны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахад чиглэсэн болно.

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн тогтолцооны хөгжлийг судлаачид дараах чиг хандлагаар хөгжиж байна гэж үзсэн байна.

Дэлхийн улс орнуудын гэр бүлийн шүүхийн тогтолцоог харьцуулан судлахад дараах үр дүн харагдаж байна. Үнд, Гэр бүлийн хэргийн тоо огцом өсөж, улмаар мэргэшсэн шүүхүүдийн тоо нэмэгдэж байна. Гэр бүлийн хэрэг дэлхийн хэмжээнд шүүхийн нийт ачааллын ойролцоогоор 20 хувийг эзэлдэг. Статистик үзүүлэлтээр илэрхийлэгдэх энэхүү өсөлт нь иргэний процессын журам гэр бүлийн маргаанд хангалтгүй болохыг харуулж байгаа буюу иргэний ердийн шүүхээс гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэдэг гэр бүлийн дагнасан шүүхрүү шилжих хандлага ажиглагдаж байна. Олон салбарын хамтын ажиллагаа буюу сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон бусад мэргэжилтнийг шүүхийн ажиллагаанд оролцуулах тогтолцоо өргөжин хөгжиж байна. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлал, эвлэрэн хэлэлцэх ажиллагааг түлхүү хэрэглэдэг. Тухайн улс нь жишгийн эрх зүйд тулгуурласан, маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэхийг илүү дэмждэг нийтийн эрх зүйн бүлд эсхүл бичмэл хууль, тодорхой журамд тулгуурласан хувийн эрх зүйн бүлд ба энэхүү хоёр уламжлалт эрх зүйн бүлийн давуу талыг хослуулдаг холимог эрх зүйн бүлийн аль эрх зүйн бүлд хамаардагаас шалтгаалан Гэр бүлийн шүүхийн тогтолцоо хөгжиж байна (Paola Amey Gómez, 2024, pp. 30-33).

Гэхдээ Азийн тивийн зарим орон тухайлбал, Япон, Энэтхэг болон Израилийн эрх зүйн тогтолцоо болон Латин Америкийн (Ottawa, n.d.) улсуудын эрх зүйн зарим онцлогуудыг ажиглахад эдгээр орны эрх зүйн тогтолцооны хөгжлийн чиг хандлагад нийтийн эрх зүй буюу англо-саксоны эрх зүйн тогтолцоо нөлөөлж, хөгжлийн чиг хандлагыг нь тодорхойлж байгааг судлаачид дурджээ. Тухайлбал, Япон улсын эрх зүйн тогтолцоо нь

хэдийгээр ром германы эрх зүйн тогтолцоонд хамаардаг ч гэр бүлийн шүүх нь англо саксоны эрх зүйн бүлийн нөлөөнд үүсэж, хөгжсөн.

Гэр бүлийн шүүхийн тогтолцоо дэлхий даяар дараах 3 үе шатыг дамжин хөгжиж байгаа тухай дурджээ (Paola Amey Gómez, Principles of family procedural law, 2024, pp. 30-33).

1. Эхний үед гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хууль тогтоомж, шүүхийн практикийн хувьд иргэний хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд хамаардаг.

Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хэргийг эд хөрөнгийн маргаан хянан шийдвэрлэдэг ердийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэдэг уламжлалт тогтолцоо юм.

2. Хоёрдахь үед иргэний хэргийн тоо, түүний дотор гэр бүлийн хэргийн тоо өсөж, иргэний хэргийн шүүхийн тогтолцооны ачаалал нэмэгдэж мэргэшсэн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх үүсэх хандлага тогтдог.

Гэхдээ гэр бүлийн шүүхийн тогтолцооны онцлог, онолын үндэслэл, үзэл баримтлалаас илүү хэргийн статистик өсөлтөөс үүдэн гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх танхим эсхүл дагнасан анхан ба давж заалдах шатны шүүх байгуулагдаж эхэлдэг ажээ. Гэвч давж заалдах шатны дагнасан шүүхийн хөгжил удаан хандлагатай байдаг тул иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гэр бүлийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэдэг. Мөн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зарим эрх зүйн зохицуулалт нь иргэний процессын хуульд хэвээр үлддэг. Гэр бүлийн дагнасан шүүхийн мэргэшсэн шүүгч, бусад албан тушаалтны нөөц бага, тэднийг сургах, мэргэшүүлэх болон хүүхдэд ээлтэй шүүхийн байр, танхим бэлтгэх зэрэг дагнасан шүүхийн тогтолцоог хөгжүүлэх хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байдаг байна.

3. Гуравдахь үе нь гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны хөгжлийн хамгийн боловсронгуй түвшин бөгөөд системийн бүх бүрэлдэхүүн хэсэг, түүний үйл ажиллагааны арга, арга зүй бүрэн мэргэшиж нарийссан байдаг.

Иймээс гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх гурав дахь үеийн тогтолцоог “хувь хүнд тохирсон” чиг хандлагыг баримталдаг бүрэн хөгжлийн үе шат гэж нэрлэжээ. Герман ба Австрали Улсын Гэр бүлийн шүүхийн систем болон Латин Америкийн орноос Коста Рика Улсад хөгжиж буй шинэ чиг хандлага бүхий загварыг энэ түвшинд хамааруулжээ. (Paola Amey Gómez, Diego Benavides Santos, 2024,52-55).

Энэ шатанд гэр бүлийн маргааныг хүний эрхэд нийцүүлэн үр дүнтэй шийдвэрлэхэд чиглэнэ. Шүүхийн бүх шатанд гэр бүлийн маргааны эмзэг, нарийн төвөгтэй шинжийг онцгойлон анхаардаг мэргэшсэн буюу дагнасан гэр бүлийн шүүхүүд ажиллана. Гэр бүлийн харилцааны онцлогт тохирсон процессын бие даасан хуультай, мэргэшсэн хуульчдаас гадна олон салбарын мэргэжитнүүдийн (сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын мэргэжилтэн) хамтын ажиллагаанд тулгуурласан хүн төвтэй, хүүхдийн дээд эрх, ашиг сонирхолд суурилсан шүүхийн тогтолцоо төлөвшдөг. Гэр бүлийн шүүх нь гадаад орчин, дотоод зохион байгуулалтын хувьд хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт нийцсэн тусгайлан зориулагдсан байртай байхаас гадна иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд хүртээмжтэй байна.

Харин манай улсын хувьд өнөөдрийн байдлаар гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа иргэний процессын хуулиар зохицуулагдаж байгаа хэдий ч Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулагдан, мэргэжлийн байгууллага, албан хаагчид, хуульчид болон ард иргэдээр хэлэлцүүлэх шатанд байна. Иймд дэлхийн улс орнуудын Гэр бүлийн шүүхийн тогтолцооны хөгжлийн дээрх үе шаттай харьцуулахад Монгол Улс дагнасан шүүхийн тогтолцоо байгуулах 2 дахь шатанд шилжихээр бэлтгэж байна.

Ийнхүү гэр бүлийн хэргийг эхний үед ердийн иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэдэг байсан бол дараагийн шатанд хэрэг маргааны тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор мэргэшэх хандлага бий болдог ажээ. Улмаар гуравдугаар үед хүний эрхэд суурилсан, олон салбарын мэргэжилтний оролцоотой, бүрэн мэргэшсэн шүүх гэр бүлийн хэргийг шийдвэрлэдэг шүүхийн тогтолцоо хөгждөг байна. Сүүлийн үе шатанд Гэр бүлийн шүүхийн тогтолцооны зорилго нь зөвхөн маргаан шийдвэрлэх биш, харин хүний эрхийг хамгаалах, хүүхдийн ашиг сонирхолыг хангах зарчимд тулгуурласан гэр бүлийн гишүүдийн сайн сайхан байдал, хөгжлийг дэмжихэд чиглэдэг байна.

Латин Америкийн улсууд ч дээрх үе шатуудыг дамжин хөгжиж байна. Тухайлбал Уругвай, Колумб, Эквадор, Куба зэрэг улсуудад эрүүгийн хэргээс бусад бүх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг нэг процессын хуулиар эсхүл гэр бүлийн хэргийг иргэний процессын хуулиар шийдвэрлэж иржээ. Харин зарим улсад гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай журмыг уламжлалт загварт нэмсэн буюу холимог шинжтэй зохицуулалт байдаг байна. Жишээ нь, Гватемал улсад 1964 оны 05 сарын 07-ны өдөр Гэр бүлийн шүүхийн тухай хууль (Family Courts Law №206) батлагдсан ч иргэний процессын

хууль хэрэглэдэг, гэхдээ шүүгчдэд тухайн хэрэг, хувь хүнд тохирсон журам хэрэглэх, уян хатан шийдвэр гаргах эрх мэдэл олгогдсон байна. Мөн Куба Улсад Дээд шүүхийн зөвлөлийн баталсан 2007 оны 12 сарын 20-ны өдрийн 187 дугаартай, 2012 оны 05 сарын 17-ны өдрийн 216 дугаартай журам болон иргэний процессын хуулийг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхдээ баримтлахаар заажээ.

Ийнхүү хэдийгээр зарим улс орнууд гэр бүлийн процессын хуулийг тусад нь бие даан батлаагүй ч шүүхийн заавар, тусгай чиглэл, аргачлалыг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхдээ баримталдаг байна.

Гэтэл Панам, Боливи, Никарагуа, Доминиканы БНУ-д гэр бүлийн материаллаг эрх зүй ба процессын эрх зүйн харилцааг нэг кодекс хуулиар зохицуулдаг. Харин гэр бүлийн процессын эрх зүйн харилцаа нь тусдаа бие даасан хуулиар зохицуулагддаг улс орнууд ч байдаг. Жишээ нь Сальвадор Улс 1994 онд, Чили Улс 2014 онд, харин Коста Рика Улсад 2019 онд тус тус Гэр бүлийн процессын хууль батлагджээ.

Гэр бүлийн дагнасан шүүхээс гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах процессын хууль нь хүүхдийн дээд ашиг сонирхолыг хангах, гэр бүлийг хамгаалахад чиглэсэн олон улсын гэрээ конвенц болон материаллаг эрх зүйн хэм хэмжээг амьдралд хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсад Gerichtsverfassungsgesetz (GVG) хуулиар 1977 онд гэр бүлийн шүүх байгуулах үндсийг тавьсан бол 2008 онд баталсан Gesetz über das Verfahren in Familiensachen und in den Angelegenheiten der freiwilligen Gerichtsbarkeit (FamFG) хуулиар гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг орчин үеийн түвшинд зохицуулжээ. Gerichtsverfassungsgesetz (GVG) хуульд орон нутгийн шүүхэд гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай нэгж (гэр бүлийн шүүх) байгуулна гэж заасан ((GVG)).

Эрүүгийн хэргийн шүүхээс тусад нь Өсвөр насны хүний хэргийн шүүх болон Гэр бүлийн шүүхийг бөйгуулсан шалтгаан нь хүүхдийн холбогдсон хэргийг тусад шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм. Энэхүү тогтолцоо сайн ажиллаж байна гэдгийг хэлэх нь зүйтэй юм (Сшал, 2025, р. 56).

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулдаг хууль (Act on Proceedings in Family Matters and in Matters of Non-Contentious

Jurisdiction, FamFG) (<https://www.gesetze-im-internet.de/>, n.d.) нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор олон талт процессын баталгааг тусгасан байдаг. Тухайлбал, хүүхэдтэй холбоотой хэрэгт шүүх нь хөндлөнгийн байр сууринаас бус харин идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг. Мөн асрамж, эцэг, эхтэйгээ уулзах боломж зэргийг тогтооход хүүхдийг биечлэн сонсох үүргийг шүүх хүлээсэн байдаг (§159, Act on Proceedings in Family Matters and in Matters of Non-Contentious Jurisdiction (FamFG), 2008). Энэхүү зохицуулалт нь хүүхдийн санаа бодлыг шүүхийн шийдвэр гаргах үйл явцад тусгах боломжийг бүрдүүлдэг бөгөөд Хүүхдийн эрхийн конвенцид заасан “хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” эрхийн хэрэгжилтийг хангаж байна (Хүүхдийн эрхийн тухай конвенц). Гэхдээ хүүхдийн илэрхийлсэн байр суурь нь шууд хэргийг шийдвэрлэх хүчин зүйл биш бөгөөд харин “хүүхдийн дээд ашиг сонирхол” (Хүүхдийн эрхийн конвенц) -ыг хангах хүрээнд үнэлэгдэх нэг чухал хүчин зүйл болдог. Хүүхэд хамгааллын байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн амьдрах орчин, нийгмийн нөхцөл байдал, эцэг эхийн хүүхдээ хүмүүжүүлэх чадавхийн талаар мэргэжлийн дүгнэлт гаргадаг (§162 FamFG). Энэ нь шүүхийг бодит нөхцөл байдалд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг. Шүүх хүүхдийн асран хамгааллын маргаанд хүүхдийн сэтгэл зүйн байдал, эцэг эхтэйгээ харилцах харилцаа, аюулгүй байдлыг үнэлэхэд шинжээч томилж, сэтгэл зүйн болон мэргэжлийн дүгнэлт гаргуулдаг. Шүүх нь уг дүгнэлтэд шууд үндэслэж шийдвэр гаргахгүй, бусад нотлох баримтуудтай харьцуулан үнэлж шийдвэр гаргадаг (§26 FamFG)

Дээрх зохицуулалтаас харвал Герман Улсын гэр бүлийн процессын хууль нь хүүхдийн эрхийг бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн орчин үеийн хандлагын тод жишээ юм.

Ийнхүү Гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн иргэний процессын хуульд багтаах бус, харин гэр бүлийн харилцааны онцлог, хэрэгцээ болон хувь хүнд тохирсон тусгай хууль, тусгай журам, тусгай институт бүхий процессын тогтолцоог бий болгох хандлага дэлхийн олон улсад хөгжиж байна.

Манай улсын хувьд 1921-1960 оны Үндсэн хууль үйлчилж байх үед гэр бүл, түүнтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэж байсан тухай

Ардын хувьсгалын анхны жилүүдээс өмнө төр захиргаа, эрүү, иргэн ба процессын эрх зүйн харилцааг нэг хуульд багтаан зохицуулдаг байсан бол 1921 оны анхны Үндсэн хууль батлагдсанаас хойш бие даасан хуулиудаар зохицуулах болсон.

Үүний нэг илрэл нь 1926 онд баталсан Иргэний хууль нь Гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан анхны хууль юм. Тухайлбал, сайн дурын үндсэн дээр гэр бүл болох боловч эцэг, эхээс зөвшөөрөл авах, шашин шүтлэгээр нь ялгаварлаж болохгүй, эр, эмийн хэлхээ холбоог эвдэн гэр өрхийг сарниулсан этдээдийг Шүүх цаазын бичгийн ёсоор ял эдлүүлэх, гэрлэлт цуцлах, үр хүүхэд үрчлэх, эд хөрөнгийн гэрээ байгуулах гм харилцааг зохицуулсан байна. Энэхүү эрх, үүргээ зөрчвөл 1934 оны 01 сарын 15-ны өдөр батлагдсан Улаанбаатар хотын хороодын захиргаанаас жижиг Эрүүгийн ба Иргэний хэргийг таслан шийтгэх тухай дүрэм (Монголын хууль тогтоомжийн эмхтгэл, Гуравдугаар боть (1958 XI сар – 1970 он), 2010 он, 398-401 дэх тал)-д зааснаар шийдвэрлэж байсан.

1952 оны 5 сарын 27-ны өдөр БНМАУ-ын Иргэний шинэ хуулийг баталсан байх ба энэ хуульд гэр бүл, гэр бүлийн эд хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулаагүй байна. Энэ өдөр БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийг баталж иргэний хэргүүдийг хянан шийдвэрлэх, давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах процесс ажиллагааг зохицуулсан хууль баталсан. Мөн гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх журмыг нарийвчлан зохицуулаагүй.

Харин 1956 оны 04 сарын 26-нд БНМАУ-ын Гэрлэх ба гэр бүл, асрамж, тэтгэмжийн тухай хууль баталж, гэр бүл болоход чухалчлах зүйл, гэрлэгсдийн эрх, үүрэг, гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүмүүсийн харилцаа, хүүхэд өргөж авах, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбоотой харилцаануудыг зохицуулсан.

1963 оны 2 сарын 9-ний өдөр баталсан БНМАУ-ын Иргэний хуулийн 83 дугаар зүйлд Гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмч нь Гэрлэлт ба гэр бүлийн тухай хуулиар зохицуулагдах тухай заасан.

1967 оны 6 сарын 29-нд БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль баталсан. Энэ хуульд хэргийн оролцогчид хууль, шүүхийн тэгш байх, шүүгч хараат бус байх, шүүх хуралдаан нээлттэй байх, тасралтгүй явагдах зэрэг зарчмуудыг бэхжүүлсэн. Мөн “Гэрлэлт цуцлах тухай байцаан шийтгэх ажиллагаа” гэдэг бүлгээр гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэл гаргах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах ба гэрлэгсдийн дундын эд хөрөнгийг хуваах, гэрлэгсэд шүүх хуралдаанд оролцох үүрэг, гэрлэгсдийг эвлэрүүлэх талаар бололцоотой бүх арга хэмжээг шүүхээс авах, шүүх гэрлэлт цуцлах шалтгааныг тогтоох гм харилцааг зохицуулжээ.

1973 оны 4 сарын 19-нд БНМАУ-ын Гэр бүлийн тухай хуулийг баталсан. 1956 оны БНМАУ-ын Гэрлэх ба гэр бүл, асрамж, тэтгэмжийн тухай хуульд заасан харилцааг улам боловсоронгуй болгосноос гадна гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, эх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, эцэг, эх, хүүхдийн эрх, эцэг, эх, хүүхэд болон төрөл саднаа тэжээн тэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар заажээ. Энэ хууль нь 1999 оныг хүртэл үйлчилсэн.

1990-ээд оноос Монгол Улс улс төр, нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжсэнтэй уялдан 1992 оны Үндсэн хуулийг баталсан.

Үндсэн хуульд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цоглуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно хэмээн даяар олноо зарлан тунхагласан тул Монгол Улсад шинэ үеийн нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн шинэчлэлт өрнөсөн юм.

Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль батлагдсан үеэс гэр бүл, хүүхэдтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэж байсан дээр дурдсан материаллаг болон процессын хуулиудад хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

Харин 1999 онд Гэр бүлийн тухай хууль, 2002 онд Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинээр баталж, хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орон өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байна.

Иргэний хуулиар гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө, түүнээс гишүүнд оногдох хэсгийг тодорхойлох, хуваах эрх зүйн харилцааг зохицуулж байна (зүйл). Харин Гэр бүлийн тухай хуулиар (он) гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар бүлэгт Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульчилсан. Энэхүү бүлэгт гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргах болон хүүхдийг эцэг, эхийн хэн нэгэн дээр байлгах, гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах, орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулах эрхийг хориглох зэрэг гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ авах үндэслэл, журмыг заасан.

Мөн гэрлэгчид шүүх хуралдаанд өөрсдөө ирэх, гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох, эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа авах, энэ хугацаанд эвлэрээгүй эсхүл гэр бүлийн хүчирхийлэлтэй бол гэрлэлтийг цуцална. Гэрлэлтийг цуцлахдаа хүүхдийг эцэг, эхийн хэний асрамжинд үлдээх, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах тухай асуудлыг нэхэмжлэлийг үндэслэн шийдвэрлэж, ердийн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гаргадаг.

Ийнхүү Монгол Улсад гэр бүлийн харилцаа, түүнтэй холбоотой эд хөрөнгийн харилцааг Гэр бүлийн тухай хууль, Иргэний хуулиар зохицуулж, харин дээрх харилцаатай холбоотой маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний хэргийн ердийн шүүхээр хянан шийдвэрлэж байна.

Харин 2021 онд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж Үндсэн хуульд нийцүүлсэн бөгөөд 2024 онд шинэчлэн найруулсан Шүүх байгуулах тухай хуульд Гэр бүл, хүүхдийн дагнасан шүүхийг тойргийн зарчмаар байгуулахаар заасан. Иймээс нийслэлийн 6 дүүрэг болох Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг харьяалах Гэр бүл, хүүхдийн анхан шатны, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг хамаарах Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүхийг Улаанбаатар хотод байгуулахаар заасан.

Манай улсад нийслэлийн 6 дүүрэгт хамаарах гэр бүлийн тойргийн шүүх байгуулах шалтгаан нь хэргийн ачааллаас хамаарч байна. Тухайлбал, Нийслэлийн төвийн 6 дүүргийн эрүү, иргэний хэргийн шүүхийн ачаалал байвал зохих хэмжээнээс 42-51 хувиар өндөр байна (форум, Шүүхийн тогтолцоо: тойргийн болон дагнасан шүүх /бодлогын шүүх/, 10 дахь тал, 2021)¹. Үүний дотор Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 5 жилийн дундаж нь нийт иргэний хэргийн 10.1 хувь байна (Хууль зүй, 2025)². Мөн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх давж заалдах шатны шүүхийг зөвхөн нийслэлд байгуулахаар заасан. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 2 дугаар бүлэгт заасан гэр бүлийн хэргийг шүүх харьяалан шийдвэрлэхдээ зарим тохиолдолд

¹ Нээлттэй нийгэм форум. Шүүхийн тогтолцоо: тойргийн болон дагнасан шүүх /бодлогын шүүх/, 2021 он. 10 дахь тал

² Хууль зүй, дотоод хэргийн яам. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, 2025, 3-4 дэх тал

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэхээр заасан байна.

Дүгнэлт, санал

Инийхүү Монгол Улс анхны Үндсэн хууль үйлчлэх үед эрүү, иргэний хэргийг нэг процессын хуулиар шийдвэрлэж байсан бол 1957 онд Иргэний процессын хууль батлагдаж, нэмэлт өөрчлөлт орж, шинэчлэн найруулагдаж ирсэн бөгөөд иргэний хэрэг, түүний дотор гэр бүлийн хэргийг иргэний процессын хуульд заасан журмаар шийдвэрлэж ирсэн. Харин одоо гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үндэслэл, журмыг баримтлахаар болж хуулийн төсөл хэлцэгдэж байгаа боловч иргэний процессын хуулиас гэр бүлийн процессын хууль бүрэн салж тусгаарлагдах шинжгүй харагдаж байна.

Дэлхийн улс орнуудын гэр бүлийн шүүхийн чиг хандлагад шилжихэд Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалт чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Иймд Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал болон эрх зүйн зохицуулалтад дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд “Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг дээдлэх” зарчмыг зааж, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3-6 дугаар зүйлд заасан зарчмыг удирдлага болгохоор заасан. Хүүхэд гэр бүлтэйгээ хамт байснаар хүүхдийн эрх, ашиг хамгийн сайн хангагдах тул хуулийн зорилт хэсэгт “гэр бүлийн харилцааг хамгаалах, дэмжих” тухай үзэл баримтлалыг нэмж хуульчилах шаардлагатай юм.
2. Монгол улс Хүүхдийн эрхийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хүүхэд санаа бодлоо илэрхийлэх эрхийг зөвхөн 7-оос дээш насаар хязгаарлахгүйгээр өөрийгөө үгээр болон үйлдлээр илэрхийлэх боломжтой аль ч насны хүүхдийн саналыг хүүхдийн сэтгэл зүйчийг байлцуулан асуух, 14-өөс дээш насны хүүхэд Иргэний хуульд зааснаар хэдийгээр бүрэн бус чадамжтай ч өөрийгөө бүрэн илэрхийлэх чадвартай тул түүнийг хүсэлтээр нь шүүх хуралдаанд оролцуулах.

3. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судалж, үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь сэтгэл судлал, боловсрол, нийгмийн хамгаалал эсхүл социологийн чиглэлээр баклаврын зэрэгтэй хүн байхаар заасан. Гэтэл гэр бүлийн маргааны улмаас гэр бүлийн гишүүд, ялангуяа хүүхдийн сэтгэл зүй хямарсан байдаг шинжээчид тавих дээрх шаардлагад хүүхдийн сэтгэл зүйч мэргэжилтэй байх шаардлага нэмж тавих нь зүйтэй юм.
4. Мөн шинжээч нь тухайн хүүхэд, гэр бүлийн гишүүд сэтгэл зүйн зөвөлгөө, үйлчилгээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлдог байх, хэрэв шаардлагатай бол мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах боломжийг хуульчлах. Учир нь цаашид гэрлэлт цуцалсан ч хүүхэд болон эцэг, эхийн харилцаа хэвийн үргэлжлэхэд сэтгэл зүйн зөвөвлөгөө, үйлчилгээ нь ач тус үзүүлнэ гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж:

Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монголын хууль тогтоомжийн эмхтгэл, (2010). Гуравдугаар боть (1958 XI сар – 1970 он), 398-401
2. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 12, 37 дугаар зүйл.

Б. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Нээлттэй нийгэм форум. (2021 он). Шүүхийн тогтолцоо: тойргийн болон дагнасан шүүх /бодлогын шүүх/, 10
2. Стефан Сшал. (2025 он). Холбооны Бүгд Найрамдах Герман Улс дахь Өсвөр насны хүний Эрүүгийн эрх зүй, Дагнасан шүүхийн тогтолцоо, 156
3. Хууль зүй, дотоод хэргийн яам. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, (2025). 3-4

В. Анли хэл дээр

1. Act on Proceedings in Family Matters and in Matters of Non-Contentious Jurisdiction, FamFG, (2008). §159,
2. Paola Amey Gómez, Diego Benavides Santos, (2024). Principles of family procedural law, 30-33

Г. Цахим эх сурвалж

1. <https://www.oijj.orgites/>, OIJJ – International Juvenile Justice Observatory (Олон улсын өсвөр үеийн шударга ёсны ажиглалтын байгууллагын цахим хаяг)
2. <https://www.academia.edu>
3. <https://www.juriglobe.ca/eng/sys-juri/class-poli/droit-civil.php> Канадын Оттавагийн Их Сургуулийн Хууль зүйн факультетийн JuriGlobe судалгааны төслийн цахим хуудас